



ХЭНГИЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2021 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 08.

Чингис хот

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хууль, эрх зүйн хэлтсийн даргын
сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай


Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4, 27 дугаар зүйлийн 27.1, 27.1.1 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.6, 3.5, 3.5.4, 2019 оны 14 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7.1, 7.2, 7.4, 7.6, 7.7, 2019 оны 16 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам”, 2020 оны 141 дүгээр “Төрийн албаны тусгай шалгалтыг зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны тусгай шалгалтаар хамгийн өндөр оноо /118/ авсан Баатарцогтын Дарханбаатарыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн даргын сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2. Нэр дэвшигч Б.Дарханбаатарыг тухайн албан тушаалд томилсон шийдвэрийг ажлын 14 өдрийн дотор албан бичгээр ирүүлэх шаардлагатайг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д зөвлөсүгэй.

3. Энэхүү тогтоолыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргад хүргүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга /Ж.Саруултөгс/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР